



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/167/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	4
3.1 Ерөнхий зүйл .....	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	4
3.4 Материаллаг байдал .....	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	7
3.8 Аудитын гол асуудал .....	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	7
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	7
4. Аудитын илрүүлэлт .....	8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	9

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

᠒᠐᠒᠒.᠐3.᠒3 № 307

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Хэрлэнбаян улаан тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

---

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

---

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,716,457.57</b>	<b>9,374,115.40</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	224,902.17	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	224,902.17	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	-
34713	Цалингийн урьдчилгаа	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,491,555.40	9,374,115.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	-
35130	Эм боох материал	-	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,491,555.40	9,374,115.40
35410	Бичиг хэргийн материал	390,000.00	399,700.00
35420	Аж ахуйн материал	2,105,860.00	1,715,860.00
35440	Тулш, шатах тослох материал	-	-
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	1,006,640.00	1,269,500.00
35470	Бусад хангамжийн материал	5,989,055.40	5,989,055.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>146,406,084.83</b>	<b>149,795,117.49</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	146,406,084.83	149,795,117.49
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	142,925,584.94	146,484,617.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	132,926,198.00	132,926,198.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(897,902.25)	(6,677,302.17)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,123,377.04	16,669,562.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,593,111.23)	(6,128,879.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,082,730.98	6,871,621.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,060,806.46)	(2,170,081.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,039,586.40	7,039,586.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,915,592.40)	(3,267,192.40)
39217	Ном	1,221,104.86	1,221,104.86
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	3,480,499.89	3,310,500.01
39301	Програм хангамж	780,000.00	780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(567,500.11)	(737,499.99)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,268,000.00	3,268,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>156,122,542.40</b>	<b>159,169,232.89</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>156,122,542.40</b>	<b>159,169,232.89</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	156,122,542.40	159,169,232.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,654,023.00	9,654,023.00
51101	Өмч - төрийн	9,654,023.00	9,654,023.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	128,063,665.30	131,110,355.79
51210	Өмнөх үеийн үр дүн	128,063,665.30	128,063,665.30
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,046,690.49
51300	Хөрөнгийн дахин үнэлээний зөрүү	18,404,854.10	18,404,854.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>156,122,542.40</b>	<b>159,169,232.89</b>

Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төрлөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>192,203,924.00</b>	<b>76,196,475.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>123,146,424.00</b>	<b>11,335,075.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	123,146,424.00	11,335,075.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123,146,424.00	11,335,075.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	271,726.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	122,874,698.00	11,335,075.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>69,057,500.00</b>	<b>64,861,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	61,151,800.00	56,040,100.00
131007	Тусгай зориулалтын пилжүүдгээс санхүүжих	61,151,800.00	56,040,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	36,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		36,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	7,905,700.00	8,785,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,905,700.00	8,785,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>68,098,133.53</b>	<b>73,149,785.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>68,098,133.53</b>	<b>73,149,785.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	66,213,832.52	73,085,614.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	46,387,091.17	44,963,737.28
210101	Үндсэн цалин	41,574,990.00	33,271,563.28
210102	Нэмэгдэл	715,541.00	7,054,155.00
210104	Урамшуулал	4,096,560.17	4,638,019.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,522,139.65	5,712,424.86
210201	Тэтгэврийн даатгал	3,697,316.35	4,037,454.01
210202	Тэтгэмжийн даатгал	445,533.31	414,278.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	367,810.68	337,210.05
210204	Ажилгүйдлийн даатгал	91,952.61	80,403.55
210205	Эрүүл мэндийн даатгал	919,526.70	843,078.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай хөлбөтөй тогтмол зардал</b>	7,394,932.00	8,983,629.38
210301	Гэрэл, цахилгаан	691,932.00	1,787,629.38
210302	Түлш, халаалт	5,908,000.00	6,006,000.00
210303	Цэвэр, бохир ус	795,000.00	1,190,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,139,350.00	623,250.00
210401	Бичиг хэрэг	135,800.00	15,500.00
210402	Тээвэр, шатахуун	298,750.00	6,000.00
210403	Шуудан, холбоо, интернетын төлбөр	406,600.00	297,400.00
210404	Ном, хэвлэл	9,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	239,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,500.00	64,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал ахисны зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,585,370.00	4,024,030.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,900.00	8,900.00
210502	Хоол, хүнс	3,441,170.00	4,015,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	85,300.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	485,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл		
210604	Урсгал засвар	-	485,000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоод албан томилголт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,860,949.70	7,969,542.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,500.00	23,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,600.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,803,849.70	7,946,042.84

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,884,301.01	64,170.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,068.00	570.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,068.00	570.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,479,233.01	63,600.03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,479,233.01	63,600.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>124,105,790.47</u>	<u>3,046,690.49</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>124,105,790.47</u>	<u>3,046,690.49</u>

Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	3,957,874.83	32,016,751.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	3,957,874.83	32,016,751.93
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			124,105,790.47	124,105,790.47
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	128,063,665.30	156,122,542.40
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	128,063,665.30	156,122,542.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	128,063,665.30	156,122,542.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	1 адаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			3,046,690.49	3,046,690.49
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,654,023.00	18,404,854.10	131,110,355.79	159,169,232.89

Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>69,329,226.00</b>	<b>64,861,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>271,726.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>271,726.00</b>	<b>-</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	271,726.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	271,726.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>69,057,500.00</b>	<b>64,861,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>61,151,800.00</b>	<b>56,040,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгсэ санхүүжих	61,151,800.00	56,040,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>36,100.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>7,905,700.00</b>	<b>8,785,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,905,700.00	8,785,200.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>69,329,226.00</b>	<b>64,861,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>69,329,226.00</b>	<b>64,861,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>67,444,924.99</b>	<b>64,797,229.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>46,133,847.00</b>	<b>44,633,072.54</b>
210101	Үндсэн цалин	35,337,254.00	32,940,898.54
210102	Нэмэгдэл	6,822,100.00	7,054,155.00
210104	Урамшуулал	3,974,493.00	4,638,019.00
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>6,000,285.99</b>	<b>5,818,187.43</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,425,485.99	4,161,791.33
210202	Тэтгэмжийн даатгал	393,800.00	448,055.53
210203	ҮОМШО-ний даатгал	314,900.00	322,204.15
210204	Ажил гүйцэтгэлийн даатгал	78,700.00	80,576.04
210205	Эрүүл мэндийн даатгал	787,400.00	805,560.38
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,394,932.00</b>	<b>8,299,629.38</b>
210301	Гэрэл, цахилгаан	691,932.00	1,787,629.38
210302	Түлш, халаалт	5,908,000.00	5,712,000.00
210303	Цэвэр, бохир ус	795,000.00	800,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,456,850.00</b>	<b>926,950.00</b>
210401	Бичиг хэрэг	515,800.00	15,500.00
210402	Тээвэр, шатахуун	298,750.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	406,600.00	297,400.00
210404	Ном, хэвлэл	9,700.00	9,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	340,000.00	239,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	886,000.00	64,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,418,010.00</b>	<b>4,286,890.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,900.00	8,900.00
210502	Хоол, хунс	3,677,810.00	4,277,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн элдэл	681,300.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>505,700.00</b>	<b>485,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210604	Урсгал засвар	505,700.00	485,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>324,000.00</b>	<b>324,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>211,300.00</b>	<b>23,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,500.00	23,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	187,800.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,884,301.01</b>	<b>64,170.65</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,068.00	570.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,068.00	570.62

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,479,233.01	63,600.03
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,479,233.01	63,600.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,825,300.00	64,761,129.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,825,300.00	64,761,129.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,825,300.00	64,761,129.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,660,700.00	44,633,072.54
210101	Үндсэн цалин	33,200,300.00	32,940,898.54
210102	Нэмэгдэл	6,822,100.00	7,054,155.00
210104	Урамшуулал	4,638,300.00	4,638,019.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,852,700.00	5,818,187.43
210201	Тэтгэврийн даатгал	4,241,500.00	4,161,791.33
210202	Тэтгэмжийн даатгал	402,800.00	448,055.53
210203	ҮОМШО-ний даатгал	322,200.00	322,204.15
210204	Ажлын үйлдлийн даатгал	80,600.00	80,576.04
210205	Эрүүл мэндийн даатгал	805,600.00	805,560.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,300,000.00	8,299,629.38
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	1,787,629.38
210302	Түлш, халаалт	5,500,000.00	5,712,000.00
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	891,800.00	890,850.00
210401	Бичиг хэрэг	15,800.00	15,500.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	297,800.00	297,400.00
210404	Ном, хэвлэл	9,700.00	9,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутга	240,000.00	239,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,500.00	28,500.00
2105	Нормативт зардал	4,287,400.00	4,286,890.00
210501	Эм, бөлдмөл, эмгэлгийн хэрэгсэл	8,900.00	8,900.00
210502	Хоол, хүнс	4,278,500.00	4,277,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,200.00	485,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	485,200.00	485,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураал	324,000.00	324,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,500.00	23,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,500.00	23,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	64,825,300.00	64,761,129.35
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	56,040,100.00	55,976,499.97
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	56,040,100.00	55,976,499.97
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	8,785,200.00	8,784,629.38
132001	Орон нутгийн төсвөөс	8,785,200.00	8,784,629.38

Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг

## АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>36,100.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	36,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	36,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	36,100.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		36,100.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>36,100.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	36,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		36,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор О.Энхтунгалаг, аудиторын туслах М.Мөнхзаяа нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаа сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 68,098.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 681.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 544.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,091.7 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	224.9	-	(224.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	9,491.5	9,374.1	(117.4)
Үндсэн хөрөнгө	146,406.1	149,840.1	3,434.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>156,122.5</b>	<b>159,214.2</b>	<b>3,091.7</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,654.0	9,654.0	-
Хуримтлагдсан үр дүн	128,063.7	131,155.4	3,091.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,404.8	18,404.8	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>156,122.5</b>	<b>159,214.2</b>	<b>3,091.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл нь 9,374.1 мянган төгрөг болж 117.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 11,621.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 11,738.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 149,840.1 мянган төгрөг болж 3,434.0 мянган төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж 7,546.2 мянган төгрөгийн, тавилга эд хогшил 3,838.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлогоор нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 7,950.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хорогджээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 131,155.3 мянган төгрөг болж, 3,091.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлтөөс нөлөөлсөн байна..

Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан тосгоны Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 115,957.9 мянган төгрөгөөр буюу 139.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт, 5,075.6 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй авсан орлого 111,761.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 5,056.2 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл нэмэгдэл цалингийн зардал 6,338.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 69,329.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,989.1 мянган төгрөгөөр бүүруулан нийт зарлагыг 65,340.1 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Хангамж, бараа материалын зардлыг 1,529.9 мянган төгрөгөөр цалингийн зардлыг 1,500.8 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 1,514.8 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 64,825.3 мянган төгрөгөөр баталсанаас 56,040.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 8,785.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 56,040.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 8,785.2 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 64,761.1 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 63.6 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 0.6 мянган төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 64,761.2 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 36.1 мянган төгрөгийн орлого орж, 36.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

#### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

##### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх онд итгэл үзүүлж, аудит хийгдээгүй болно.

##### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

## **Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 40,766.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40,766.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Залруулсан алдаа байхгүй.

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Байхгүй

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.**

##### **Илрүүлэлт:**

4.4.1. Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 40.766.6 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	Хэрлэнбаян-Улаан тосгоны цэцэрлэг	1	40,766.6							1	40,766.6
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>40,766.6</b>							<b>1</b>	<b>40,766.6</b>